



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.5, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.5.1, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын аялал жуулчлал, үзвэр үйлчилгээний цагийн хуваарь, үнэ, дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр авч байх боломжтой, орон зайг мэдэрч мэдээлэл өгөх технологийн шийдэл бүхий ухаалаг хэрэгслүүдэд зориулсан аппликэйшн хийх ажилд хамгийн бага үнийн санал ирүүлсэн Би-Эс-Си-Жи ХХК-тай хууль, журмын дагуу гэрээ байгуулан ажиллахыг Мэдээллийн технологи хариуцсан инженер /Д.Монголхүү/-т даалгасугай.

2. Гэрээт ажлын нийт төсөв 20.000.000 /хорин сая/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА